



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/83-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БУГ	Боловсрол урлагийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 5 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Р.ЦОЛМОН ТАНАА

2024.08.23 № САА-2024/84-ДТТ-САА-НДЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд БШУГ-аас 2,113.3 мянган төгрөгийн ном, сурах бичиг, сумын ЗДНХ-өөс 3,290.0 мянган төгрөгийн камер, тоног төхөөрөмж, Билиг ДБС-иас 2,623.5 мянган төгрөгийн ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 23,880.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	208,178,445.66	243,903,586.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	147,608,437.51	168,422,455.13
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	147,608,437.51	168,422,455.13
3121	Төгрөг	147,608,437.51	168,422,455.13
31211	Төрийн сангийн харилцах	147,608,437.51	168,422,455.13
35	БАРАА МАТЕРИАЛ	60,570,008.15	75,481,131.25
351	Түүхий эд материал	1,552,080.71	7,270,840.57
3511	Тусгай зориулалттай материал	1,552,080.71	7,270,840.57
354	Хангамжийн материал	59,017,927.44	68,210,290.68
3541	Бичиг хэргийн материал	1,321,200.00	842,000.00
3542	Аж ахуйн материал	2,391,000.00	551,800.00
3546	Хүнсний материал	17,500.00	450,790.00
3547	Бусад хангамжийн материал	55,288,227.44	66,365,700.68
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,232,857,678.14	2,210,162,426.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,232,857,678.14	2,210,162,426.38
392	Биет хөрөнгө	2,105,917,678.14	2,083,552,426.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,673,000,000.00	1,673,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,611,111.10	-46,277,777.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,294,778.94	181,028,728.94
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,071,328.70	-34,167,286.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,009,700.00	169,177,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,867,202.80	-44,393,670.91
39214	Бусад үндсэн хөрөнгө	192,828,300.00	193,358,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,578,255.00	-12,199,192.01
39217	Ном	1,912,796.80	4,026,124.30
393	Биет бус хөрөнгө	126,940,000.00	126,610,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-110,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	125,400,000.00	125,400,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,441,036,123.80	2,454,066,012.76
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,441,036,123.80	2,454,066,012.76
51	Засгийн газрын хувь оролцоо	2,441,036,123.80	2,454,066,012.76
512	Хуримтлагдсан үр дүн	2,441,036,123.80	2,454,066,012.76
5121	Өмнөх үеийн үр дүн	2,441,036,123.80	2,441,036,123.80
5122	Тайлант үеийн үр дүн		13,029,888.96
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,441,036,123.80	2,454,066,012.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,788,536,450.58	1,213,829,128.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,328,446,433.89	34,875,640.60
120	Нийтлэг татварын бус орлого	2,328,446,433.89	34,875,640.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,408,800.00	11,866,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,408,800.00	10,085,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,781,680.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,204,688,725.74	8,026,827.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	41,348,908.15	14,982,033.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	460,090,016.69	1,178,953,487.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	450,507,800.00	1,138,713,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	450,507,800.00	1,138,713,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,582,216.69	39,240,487.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,582,216.69	39,240,487.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	347,500,326.78	1,200,799,239.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	347,500,326.78	1,200,799,239.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,986,487.78	1,121,799,709.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,575,838.07	831,667,821.76
210101	Үндсэн цалин	173,025,657.07	623,853,850.74
210102	Нэмэгдэл	54,505,942.00	181,815,687.81
210104	Урамшуулал	4,044,239.00	25,998,283.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,622,343.42	103,131,594.12
210201	Тэтгэврийн даатгал	19,838,303.63	72,349,789.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,333,917.93	8,424,711.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,850,334.34	6,616,569.12
210204	Ажилгүйдлийн даатгал	418,162.25	1,430,956.33
210205	Эрүүл мэндийн даатгал	4,181,625.27	14,309,568.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,582,216.69	31,208,737.80
210301	Гэрэл, цахилгаан	4,036,796.69	15,196,237.80

210302	Түлш, халаалт	4,768,750.00	14,250,000.00
210303	Цэвэр, бохир ус	351,670.00	937,500.00
210304	Байрны түрээс	425,000.00	825,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,572,150.00
210604	Урсгал засвар		4,572,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,243,500.00	7,780,955.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,661,300.00	1,780,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,582,200.00	6,000,355.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,962,589.60	143,438,450.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,115,392.00	27,660,821.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,609,300.00	13,537,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,237,897.60	102,240,029.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,513,839.00	78,999,530.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,513,839.00	78,999,530.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,513,839.00	62,477,230.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		16,522,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,441,036,123.80	13,029,888.96
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,441,036,123.80	13,029,888.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	542,498,816.69	1,190,820,267.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,408,800.00	11,866,780.00
120	Нийтлэг татварын бус орлого	82,408,800.00	11,866,780.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,408,800.00	11,866,780.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,408,800.00	10,085,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,781,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	460,090,016.69	1,178,953,487.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	450,507,800.00	1,138,713,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	450,507,800.00	1,138,713,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,582,216.69	39,240,487.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	9,582,216.69	39,240,487.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	331,483,529.18	1,097,488,300.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	331,483,529.18	1,097,488,300.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,952,190.18	1,019,055,480.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,575,838.07	831,667,821.76
210101	Үндсэн цалин	173,025,657.07	623,853,850.74
210102	Нэмэгдэл	54,505,942.00	181,815,687.81
210104	Урамшуулал	4,044,239.00	25,998,283.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,622,343.42	103,131,594.12
210201	Тэтгэврийн даатгал	19,838,303.63	72,349,789.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,333,917.93	8,424,711.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,850,334.34	6,616,569.12
210204	Ажилгүйдлийн даатгал	418,162.25	1,430,956.33
210205	Эрүүл мэндийн даатгал	4,181,625.27	14,309,568.13
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,582,216.69	31,362,737.80
210301	Гэрэл, цахилгаан	4,036,796.69	15,196,237.80
210302	Түлш, халаалт	4,768,750.00	14,250,000.00
210303	Цэвэр, бохир ус	351,670.00	1,091,500.00
210304	Байрны түрээс	425,000.00	825,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,112,750.00
210604	Урсгал засвар		5,112,750.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,243,500.00	7,780,955.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,661,300.00	1,780,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,582,200.00	6,000,355.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,928,292.00	39,999,621.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,078,292.00	28,063,221.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,850,000.00	11,936,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,531,339.00	78,432,820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,531,339.00	78,432,820.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,531,339.00	62,910,520.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		15,522,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	211,015,287.51	93,331,967.62
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,406,850.00	71,517,950.00

22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	63,406,850.00	71,517,950.00
	Дотоод эх үүсвэрээр	63,406,850.00	71,517,950.00
222001	Тоног төхөөрөмж	61,756,850.00	56,443,950.00
223001	Бусад хөрөнгө	1,650,000.00	15,074,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-63,406,850.00	-71,517,950.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	147,608,437.51	21,814,017.62
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		147,608,437.51
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		168,422,455.13

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,441,036,123.80	2,441,036,123.80
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			13,029,888.96	13,029,888.96
19	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			2,454,066,012.76	2,454,066,012.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,345,583,900.00	1,170,006,250.18	175,577,649.82	87.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,345,583,900.00	1,097,488,300.18	248,095,599.82	81.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,254,115,200.00	1,019,055,480.18	235,059,719.82	81.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,630,400.00	831,667,821.76	133,962,578.24	86.1

210101	Үндсэн цалин	666,456,400.00	623,853,850.74	42,602,549.26	93.6
210102	Нэмэгдэл	265,667,000.00	181,815,687.81	83,851,312.19	68.4
210104	Урамшуулал	33,507,000.00	25,998,283.21	7,508,716.79	77.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,703,900.00	103,131,594.12	17,572,305.88	85.4
210201	Тэтгэврийн даатгал	82,078,800.00	72,349,789.01	9,729,010.99	88.1
210202	Тэтгэмжийн даатгал	9,656,300.00	8,424,711.53	1,231,588.47	87.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,725,000.00	6,616,569.12	1,108,430.88	85.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,931,200.00	1,430,956.33	500,243.67	74.1
210205	Эрүүл мэндийн даатгал	19,312,600.00	14,309,568.13	5,003,031.87	74.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,065,400.00	31,362,737.80	6,702,662.20	82.4
210301	Гэрэл, цахилгаан	21,123,000.00	15,196,237.80	5,926,762.20	71.9
210302	Түлш, халаалт	14,250,000.00	14,250,000.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,692,400.00	1,091,500.00	1,600,900.00	40.5
210304	Байрны түрээс		825,000.00	-825,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	5,112,750.00	2,779,850.00	64.8
210604	Урсгал засвар	7,892,600.00	5,112,750.00	2,779,850.00	64.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,842,900.00	7,780,955.00	2,061,945.00	79.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,882,800.00	1,780,600.00	102,200.00	94.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,960,100.00	6,000,355.00	1,959,745.00	75.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,980,000.00	39,999,621.50	71,980,378.50	35.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,039,800.00	28,063,221.50	71,976,578.50	28.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,940,200.00	11,936,400.00	3,800.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,468,700.00	79,432,820.00	12,035,880.00	86.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,468,700.00	79,432,820.00	12,035,880.00	86.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,946,400.00	62,910,520.00	12,035,880.00	83.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,522,300.00	16,522,300.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		71,517,950.00	-71,517,950.00	#DIV/0!
	Дотоод эх үүсвэрээр		71,517,950.00	-71,517,950.00	#DIV/0!
222001	Тоног төхөөрөмж		56,443,950.00	-56,443,950.00	#DIV/0!
223001	Бусад хөрөнгө		15,074,000.00	-15,074,000.00	#DIV/0!
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,345,583,900.00	1,190,820,267.80	154,763,632.20	88.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,139,713,000.00	1,139,713,000.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,138,713,000.00	1,138,713,000.00	0.00	100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,958,000.00	39,240,487.80	6,717,512.20	85.4
132001	Орон нутгийн төсвөөс	45,958,000.00	39,240,487.80	6,717,512.20	85.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	159,912,900.00	11,866,780.00	148,046,120.00	7.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,522,800.00	10,085,100.00	437,700.00	95.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,781,700.00	1,781,680.00	20.00	100
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	147,608,400.00		147,608,400.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		147,608,437.51	-	147,608,437.51
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		168,422,455.13	-	168,422,455.13

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь “Сургуулийн менежментийг сайжруулах, боловсролын үйлчилгээний чанарт ахиц амжилт гаргах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Тус байгууллага нь дараах чиг үүрэгтэй ажилласан байна. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудыг судлан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтан, иргэд олон нийтэд сурталчлан таниулж, тэдний оролцоотой хэрэгжүүлэх,
- Хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлж, сургуулийн орчинд аливаа хэлбэрийн гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс сэргийлэх,
- Багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж, багшийн мэдлэг, ур чадварт гарсан ахиц үр дүнг тооцох,
- Суралцагчдыг эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургаж, аливаа гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэн батлагдсан,

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан

төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,029.9 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	147,608.4	168,422.5	20,814.0
Авлага			
Бараа материал	60,570.0	75,481.1	14,911.1
Үндсэн хөрөнгө	2,232,857.7	2,210,162.4	(22,695.3)
Нийт хөрөнгө	2,441,036.1	2,454,066.0	13,029.9
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,441,036.1	2,454,066.0	13,029.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,441,036.1	2,454,066.0	13,029.9

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 168,422.5 мянган төгрөг болж 20,814.0 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 75,481.1 мянган төгрөг болж 14,911.1 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 6,232.0 мянган төгрөгийн ном,сурах бичиг, сумын ЗДНХ-өөс 8,710.0 мянган төгрөгийн камерын туслах материал, Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагаас 40.0 мянган төгрөгийн ном зэргийг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 88,020.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж 88,091.2 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,210,162.4 мянган төгрөг болж 22,695.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 71,517.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУГ-аас 2,113.3 мянган төгрөгийн ном, сурах бичиг, сумын ЗДНХ-өөс 3,290.0 мянган төгрөгийн камер, тоног төхөөрөмж, Билиг ДБС-иас 2,623.5 мянган төгрөгийн ширээ сандлыг үнэ төлбөргүйгээр хүлээн

авсан болон 102,240.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Мандал сумын 5 дугаар сургууль нь 2022 оны 8 дугаар сард хувийн хэвшлээс төрийн өмчид шилжсэн учраас 2023 оны төсвийн төслийг боловсруулж хянуулаагүй байна.

Анх 2023 оны улсын төсвөөс 976,890.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 38,020.2 мянган төгрөг нийт 1,014,911.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийг баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин, НДШ-ийн зардлыг 208,195.2 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 8,937.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,882.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 76,955.3 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 34,701.8 мянган төгрөгөөр нийт 330,672.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,138,713.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 45,958.0 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 13,304.5 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 147,608.4 мянган төгрөг төвлөрүүлэхээр, төсвийг нийт 1,345,583.9 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,345,583.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,170,006.3 мянган төгрөгийг зарцуулж, 175,577.6 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөвт 7,155.1 мянган төгрөгийг төвлөрүүлж, 168,422.5 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,170,006.6 мянган төгрөг буюу 87.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 163,541.7 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 12,035.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,184.1	3,174.8	9.3	99.7
		2	80312- Сургалт семинар	2,052.7	615.7	1,437.0	30.0

3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,184.1	3,151.0	33.1	99.0
4	81801- Үдийн цай хөтөлбөр	74,946.4	62,910.5	12,035.9	83.9
5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	36,827.2	36,641.2	186.0	99.5
6	81823- Боловсролын багшийн сургалт	7,164.1	5,971.0	1,193.1	83.3
7	81834- Боловсролын стандарт сургалт	931,921.0	812,592.8	119,328.2	87.2
8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	207,162.2	172,986.6	34,175.6	83.5
9	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	28,519.6	28,159.9	359.7	98.7
10	83603-сурах бичгийн түрээс	1,882.8	1,780.6	102.2	94.6
11	83603- Дээд шатны төсвөөс	1,781.7	1,781.7	0.0	100.0
12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	45,958.0	39,240.5	6,717.5	85.4
13	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,000.0	1,000.0	-	100.0
Нийт		1,345,583.9	1,170,006.3	175,577.6	87.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 55,766.9 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Шанзан ташуур” ХХК, “Уужим хараа” ХХК, “Ноцох дөл” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар

сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нийт хөрөнгө 2,441,036.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,410.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус сургуулийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 214 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус сургууль нь 2022 оны 8 дугаар сард хувийн хэвшлээс төрийн өмчид шилжиж бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн учраас санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 15,250.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- “Күзмен тайж” ХХК-иас авсан 14,250.0 мянган төгрөгийн нүүрсийг бараа материалын дансанд орлого авалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн нь

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт дахь “Бараа материалын бүртгэл”-ийн 4.21-д Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: *Дт. Хангамжийн материал Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг*, Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: *Дт. Зардал /Зардлын зүйлээр/ Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- Мөнгөн гүйлгээний тайланд нэг удаагийн тэтгэмж урамшуулалд олгосон 1,000.0 мянган төгрөгийг зардлаар тусгаагүйгээс нийт цэвэр мөнгөн гүйлгээ зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3-р хавсралт дахь “Мөнгөн гүйлгээний тайлан” 6.5-д “*Мөнгөн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэрийг мөнгөн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн зарлага гэсэн хэсэгт үзүүлэх ба нийт мөнгөн орлогоос нийт мөнгөн зарлагыг хасч үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр гүйлгээг тодорхойлно*”, 6.6-д “*Үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно*”. гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 1,954.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 763.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,190.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ

5.1 Төлбөрийн акт

1. Жилийн эцэс буюу тайлант оны 12 дугаар сард шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг 4 багшид тус бүр 25.0 хувиар тооцон /*өмнөх саруудад 10-15 хувиар тооцож олгож байсан*/ 763.8 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “*Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай*” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “*Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: 1. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр буюу “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-гүйгээр үйлчилгээний албан хаагчдад 1,190.7 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, 7 хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авсан нүүрсийг шууд зардлаар бүртгэсэн	1	14,250.0			1	14,250.0	1	14,250.0				
Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг дутуу илэрхийлсэн	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				
Дүн	2	15,250.0			2	15,250.0	2	15,250.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу олгоогүй	1	763.8	1	763.8										
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	1,190.7					1	1,190.7						
	2	1,954.5	1	763.8			1	1,190.7						